

**БАГАНУУР ДҮҮРГИЙН ТӨР ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА,
ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ ХООРОНДЫН
ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧГИЙН БИЕЛЭЛТ**

2020 оны 12 дугаар сарын 28-ны өдөр

Багануур дүүрэг

Д/д	№	Санамжийн заалт	Биелэлт	Гүйцэтгэлийн хувь
1.	3.1	Дүүргийн 40 жилийн ойн хүрээнд санаачлан хийх бүтээлч ажлын хүрээнд Багануурт биотехнологийг эрчимтэй хөгжүүлэх, байгаль орчны бохирдлыг бууруулах зорилтын дагуу үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлаар бордоо хийх сургалт туршилт, үйлдвэрлэлийг зохион байгуулахад дүүргийн ЗДТГ болон нийт үйлдвэр, аж ахуй нэгж байгууллага, айл өрхүүдтэй хамтран ажиллана.	<ul style="list-style-type: none"> ✓ Багануур дүүргийн 5 хороод, 21 ААНБ-уудын 460 гаруй ажилчдад паркийн инженерүүдийн боловсруулсан ахуйн болон үйлдвэрийн хог хаягдалыг ашиглан компост бордоо хийх сургалтыг зохион байгуулахдаа БҮТП-ийн тухай ойлголт, үндсэн зорилтуудыг танилцуулах стратегитэй ажлууд маань нь маш үр дүнтэй арга хэмжээ болсон. ✓ 2018-2019 онуудад үзүүлэх сургалт хийсэн 9 айл өрхийн компост бордоог 2020 оны 05, 10 дугаар саруудад газар дээр нь үзэж танилцан, зөвлөгөө өгч ажилласан. 	100%
2.	3.2	Дүүргийн 40 жилийн ойн хүрээнд зохион байгуулах арга хэмжээнд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.	<ul style="list-style-type: none"> ✓ Дүүргийн 40 жилийн ойд зориулан бэлтгэсэн “Зуун дамнасан хөгжил” номонд паркийн хэтийн зорилго, алс ирээдүйн хөгжлийн талаар тусгаж, бүсүүдийн зураглал, хамт олны зургийн хамт материалыг бүрдүүлж өгсөн. ✓ Тайлант онд байгууллагын 3 албан хаагч 40 жилийн ойн хүндэт тэмдэг хүртсэн. 	100%
3.	3.3	Төр захиргааны байгууллагаас зохион байгуулж буй аливаа үйл ажиллагаанд хамт олноороо идэвхитэй оролцоно.	Тайлант онд дүүргээс зохион байгуулагдсан дараах арга хэмжээнүүдэд оролцсон. Үүнд: 2020.01.23 - "Тэмбүүг устгая" 2020.01.27 - Томуу, томуу төст өвчний тархалт болон шинэ корона вирусын халдвараас урьдчилан сэргийлэх сургалт 2020.07.24 - Тоон гарын үсэг хэрэглэх тухай сургалт 2020.08.31 – “Гэр бүлийн эрүүл харилцаа” сургалт 2020.09.18 – Хүний нөөцийн системтэй холбогдох сургалт 2020.09.23 – ХХҮХ-ийн цахим систем ашиглах сургалт 2020.09.25 – “Залуучуудаа сонсох өдөр” нээлттэй өдөрлөгт байгууллагын ГБХЗЗ оролцож АХА тэмцээнд түрүүлсэн. 2020.10.08 – “Мэдээлэл технологийн хүний нөөцийн хөгжил” сургалт	100%

			<p>2020.10.23 - Европын сэргээн босголт хөгжлийн банкны Жижиг дунд бизнесийн санхүүжилт, хөгжлийн групп дүүргийн ЗДТГ-тай хамтран зохион байгуулсан уулзалт</p> <p>2020.10.29 – Багануур дүүргийн гамшгаас хамгаалах бэлэн байдлын нэгдсэн арга хэмжээ</p> <p>2020.10.30 - Багануур дүүргийн ЭМТ-ийн ковид-19, сүрьеэ, ТТӨ, ХБӨ-ийн талаарх сургалт</p> <p>2020.11.09 – Багануур дахь Монголын Залуу инженерүүдийн анхдугаар чуулга уулзалт</p> <p>Багануур дүүргийн Захирагчийн ажлын албанаас 2020 онд зохион байгуулсан бүх нийтийн их цэвэрлэгээнд хамт олноороо идэвхтэй оролцож хуваарилсан газрыг цэвэрлэж, тайланг хүргүүлэн ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - 2020.02.15-ны өдөр “Хоггүй шинэлцгээе” аяны хүрээнд Сар шинийн баярыг угтсан бүх нийтийн их цэвэрлэгээ - 2020.04.04-ний өдөр Хаврын бүх нийтийн их цэвэрлэгээ - 2020.05.02-ны өдөр “Их цэвэрлэгээ – 90 минут” бүх нийтийн их цэвэрлэгээ - 2020.05.23-ны өдөр “Ногоон бүс”-ийн цэвэрлэгээ - 2020.07.10-ны өдөр Үндэсний их баяр наадмыг угтсан цэвэрлэгээ - 2020.08.07-ны өдөр “Шарилжгүй Улаанбаатар-5” аяны шарилж устгал - 2020.08.15-ны өдөр Хичээлийн шинэ жилийг угтсан цэвэрлэгээ - 2020.10.09-ний өдөр “Бүх нийтээрээ цэвэрлэгээнд нэгдье” ногоон бүсийн цэвэрлэгээ - 2020.11.20-ны өдөр Цас цэвэрлэгээ - 2020.12.18-ны өдөр Шинэ жилийг угтсан цэвэрлэгээ <p>✓ Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан иргэдийн бөөгнөрөлийг үүсгэхийг хориглосон тул Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 2010 оны 63 дугаар зарлигийг хэрэгжүүлэн албан хаагчид гэр хороололд амьдардаг</p>	
--	--	--	--	--

			<p>байгууллагын 3 ажилтны гэрийн хашаанд мод тарьж арчилгаа усалгааг хийсэн.</p> <ul style="list-style-type: none"> ✓ Дүүргийн Засаг даргын А/190 дүгээр захирамжийн хүрээнд зохион байгуулагдсан "Мод тарих өдөр"-ийн үйл ажиллагаанд албан хаагчид биечлэн оролцож чадаагүй тул Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх заалтын дагуу хандивын мөнгө цуглуулан дүүргийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд тушааж баримтыг Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын 2020 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 93 дугаартай албан бичгээр мөн албан бичигт заагдсан цахим шуудангийн хаягаар тус тус хүргүүлэв. ✓ "Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр"-ийн арга хэмжээний хүрээнд тогтоосон газарт 2020.10.12-ны өдөр цэнэг усалгааг хийв. ✓ Монгол улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын даргын баталсан "Амны хаалтаа зүүцгээе" аяны удирдамжийн дагуу холбогдох үйл ажиллагааг зохион байгуулан тайланг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтний цахим хаягаар 2020 оны 06 дугаар сарын 02-ны өдөр илгээсэн. ✓ Багануур дүүргийн Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/326 дугаар захирамжийн дагуу "Сүрьеэгүй хамт олон" үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан биелэлтийг 11 дүгээр сарын 20-ны өдөр хүргүүлсэн. ✓ УОК-ын 2020 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 04 дүгээр албан даалгавар, НОК-ын 10 дугаар сарын 27-ны өдрийн 14 дүгээр хурлын тэмдэглэлээр үүрэг болгосон "Маскаа зүүе, гараа угаая" 2 дугаар аяны хүрээнд зохион байгуулсан ажлын тайланг 7 хоног бүрийн Лхагва гарагт албан бичгээр дүүргийн Нийгмийн хөгжлийн хэлтэст, 7 хоног бүрийн Пүрэв гарагт ubhealth2020@gmail.com цахим хаягаар тус тус хүргүүлэн ажиллаж байна. 	
4.	3.4	Нийгмийн хариуцлагын хүрээнд олон нийтийн арга хэмжээнд дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.	<p>БҮТП нь Нийгмийн хариуцлагынхаа хүрээнд тайлант онд 739,000 төгрөгийг дараах үйл ажиллагаанд зарцуулсан.</p> <p>- Байгууллагын ажилчид өөрсдийн цалингаас Өндөржүүлсэн бэлэн байдлын үед 24 цагийн турш ээлжээр ажиллаж байгаа</p>	100%

			<p>дүүргийн Онцгой комисст 450,000 мян.төг, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 150,000 мян.төг тус тус хандивласан.</p> <ul style="list-style-type: none"> - Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагааны хүрээнд эрсдэлт бүлгийн 5 хүүхдүүдэд танин мэдэхүйн бэлэг бэлдэж, дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэст хүлээлгэн өгсөн. - “Бид хариуцлагатай хамт олон – Хүүхэд, гэр бүлд ээлтэй орчин” арга хэмжээний хүрээнд 9 дүгээр сард амьжиргааны түвшин доогуур залуу гэр бүлд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлсэн. - Монгол улсад /COVID-19 /корона вирус/ бүртгэгдсэнтэй холбогдуулан НЗД-ын А/1280 дугаар захирамжийн хүрээнд ажилчдынхаа эрүүл мэндийг урьдчилан сэргийлэх үүднээс 0-6 насны хүүхэдтэй эхчүүдийг гэрээсээ ажиллах нөхцөлөөр ханган ажиллуулж байна. <p>Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах үүднээс ажилчдыг нэг удаагийн бээлий, N95 амны хаалт, Паркийн нэгж болох Монхимо ХХК-ийн давхар шүүлтүүрт амны хаалт, /санитол/ гар халдваргүйжүүлэх нөхцөлөөр ханган, байгууллагын цэвэрлэгээ үйлчилгээний материал, ариутгалын бодис зэргийг хангалттай нөөцлөн жилийн эцсийн байдлаар нийт 2,283,430 мян.төг зарцуулсан.</p>	
5.	3.5	<p>Дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт болон 2020 оны нийгэм эдийн засгийн үндсэн чиглэлд тусгасан “Багануур Үйлдвэрлэл, Технологийн Парк” байгуулах ажлыг эрчимжүүлэх заалтыг байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд тууштай хэрэгжүүлнэ.</p>	<p>✓ БҮТП байгуулах бэлтгэл ажлыг хангах талаар байгууллагын дүрэмд заасан үндсэн чиг үүргүүд болон хөгжлийн 2017-2020 оны Стратеги төлөвлөгөө, жил бүрийн Үр дүнгийн гэрээнд тусгагдсан үйл ажиллагааны хөтөлбөрүүдийг 100% ханган биелүүлснээр: газар байршил, ТЭЗҮ болон ХЕТ, дэд бүтцийн зураг төсөл, хууль эрх зүй болон хөгжлийн бодлогын баримт бичгүүд, мэдээлэл технологийн хүрээнд “Багануур үйлдвэрлэл, технологийн парк”-ийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ. гэсэн заалт бүрэн амжилттай хэрэгжсэн.</p> <p>Багануур дүүргийн үндсэн чиглэлд тусгагдсан “Батлагдсан зураг төсвийн дагуу ажлыг эрчимжүүлнэ.” гэсэн заалтын хүрээнд:</p> <p>✓ БХБЯ-ны захиалгаар Паркийн цахилгаан хангамжийн зураг төслийг гүйцэтгэгч “Мон-Энержи Консалт” ХХК нь ЭХЯ-наас 07 дугаар сарын 30-ны өдөр олгосон “БҮТП болон Төмрийн</p>	100%

			<p>Үйлдвэрийн эрчим хүчний нэгдсэн ерөнхий цахилгаан хангамж"-ын 51/2020/87 тоот дугаартай Техникийн нөхцөл болон 09 дүгээр сарын 16-ны өдөр олгосон “Цахилгаан хангамжийн ажлын зураг төсөл боловсруулах №2020/Ц-61 дугаартай даалгаврын” дагуу ЦДӨХАШ-ын урьдчилсан трассын шугамын зургийг боловсруулж, ЦДҮС ТӨХК руу хянуулахаар хүргэсэн.</p> <p>✓ 7,3 км шугамыг барих ажлыг “МЕСЕС” ХХК нь геологийн судалгааны ажлаас эхлүүлсэн бөгөөд Ковид-19 цар тахалтай тэмцэх үндэсний хэмжээний үйл ажиллагааны улмаас түр зогсоосон байна.</p> <p>✓ Багануур ХК-ийн удирдлага, ТУЗ-ийн гишүүдтэй тайлант онд хамтран ажиллах, мэдээлэл солилцох чиглэлээр 2 удаагийн уулзалтыг зохион байгуулан, шаардлагатай техникийн өгөгдөл мэдээллүүдийг хүлээн авч, дараах үндсэн хоёр чиглэлээр төсөл боловсруулахаар ажиллаж байна.</p> <p>1. Багануур ХК-ийн дээрх байгууламжийг дараах зориулалтаар ашиглах боломжтой. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Дулаан, цэвэр ус, бохир усны дэд бүтцийг ХҮБ-ийн хэрэгцээнд ашиглах /Багануур ДС-аас ХҮБ хүртэл шууд холбогдсон/ • “Галуут” 110 кВ-ын дэд станцыг ХҮБ-ийн цахилгаан эрчим хүчний хангамжинд ашиглах /ХҮБ-ийн талбайгаас 100м-т байршилтай/ • Төмөр замыг ашиглах /ХҮБ-ийн 2 талбайн дундуур хөндлөн гарч БР-УБ төмөр замд шууд холбогдсон/ • Захиргааны барилгыг Паркийн нэгжүүд болон ХҮБ-ийн нийтийн үйлчилгээний зориулалтаар /ХҮБ-ийн талбайн дэргэд байршилтай/ тус тус ашиглах <p>2. Багануур ХК-ийн дээрх байгууламжийг ашиглах нөхцөлд дараах асуудлыг шийдвэрлэх шаардлагатай. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. “Галуут” 110/35/6 кВт-ын дэд станцад шугамын утсыг АС240 маркаар солих 3. 2 x 16000 кВа-ын трансформатор нэмж суурилуулах 4. Төмөр замын дутуу рельсүүдийг нөхөн тавьж сэргээх 	
--	--	--	---	--

		<p>5. Хүнд үйлдвэрийн бүсээс төмөр замын 9 м өндөр тунель хүртэл 300 м газарт авто зам тавьж орох гарах үндсэн гарц байгуулах</p> <p>6. Бүсийн дотоод дэд бүтцүүдийг батлагдсан зураг төслөөр шат дараатай байгуулах</p> <p>✓ Дээрх асуудлыг НЗД-ын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх саналыг НШУҮИГ-т уламжлан хүргүүлсэн боловч одоогоор ямар нэгэн шийдвэр ирүүлээгүй байна.</p> <p>✓ Нийслэлийн Засаг даргын 2019.06.21-ний өдрийн А/619 дүгээр захирамжаар парсад Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ болон Захиргаа, нэгдсэн үйлчилгээний төвийн барилгын зураг төсөл хийлгэх 65 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэснээр нарийвчилсан үнэлгээг “Санни трейд” ХХК-аар гүйцэтгүүлэн, 2020.02.03-ны өдөр, барилгын зураг төслийг “Нутаг консалтинг” ХХК-аар гүйцэтгүүлж 2020.07.20-ны өдөр актаар хүлээн авсан.</p> <p>✓ Багануур дүүргийн Засаг даргын 2016-2020 үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг гаргаж, 12 дугаар сарын 02-ны өдрийн 220 дугаартай албан бичгээр дүүргийн ТЗУХ-т тус тус хүргүүлсэн.</p>	
--	--	---	--

ХЯНАСАН:
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨТҮГ-ЫН ДАРГА



Ч. ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Э.ЭНХЗАЯА